



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2022 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

**Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 191.8 (нэг зуун ерэн нэгэн сая найман зуу) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаартай албан даалгаврын биелэлтээр 85.7 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байх тул дотоод хяналтыг сайжруулж ажиллахыг “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (Б.Галбадрах)-д үүрэг болгосугай.

3. “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.

3.1. Хяналт шалгалтаар удаа дараа давтагдан илэрч буй компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 17.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий маргаантай барилга, урьдчилж төлсөн зардлын дансанд бүртгэлтэй, 51.9 сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг эрчимтэй зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, өмгөөллийн мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллахад шаардагдах зардлыг баталж, хяналт тавьж ажиллах, хэрэгжилтийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тухай бүр ирүүлэх;

3.2. Шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах.

4. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Галбадрах)-д үүрэг болгосугай.

4.1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх;

4.2. Компанийн мөнгөн хөрөнгийн нөөц болон урсгалыг зөв оновчтой төлөвлөж, өндөр хүүтэй зээлийн эх үүсвэрээс зайлсхийх;

4.3.Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр “Тэнгэрийн шугам” ХХК-иас худалдан авсан тээврийн хэрэгслийн улсын дугаар, гэрчилгээг компанийн нэр дээр авах асуудлыг хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлүүлэх;

4.4.Компанийн санхүүгийн тайланд бүртгэлтэй, 7 ширхэг машин механизмд улсын дугаар авах, гэрчилгээжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

4.5.Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ суманд байрлах, шуурхайн байранд хамаарах газар эзэмших эрхийг баталгаажуулж Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолын дагуу үнэлэх, санхүүгийн тайланд тусгах;

4.6.Мөрөн-Хатгал чиглэлийн 100.3 км улсын чанартай замыг “Хөвсгөл зам” ХХК-д шилжүүлсэн тул 7.1 сая төгрөгийн балансын үнэ бүхий шуурхай ажлын хэсгийн байрны ашиглалтыг сайжруулах талаар санал боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлэн шийдвэрлүүлэх;

4.7.Компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 17.3 (арван долоон сая гурван зуу) сая төгрөгийн балансын үнэ бүхий маргаантай барилга, урьдчилж төлсөн зардлын дансанд бүртгэлтэй, 51.9 (тавин нэгэн сая есөн зуу) сая төгрөгийн авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлэх, идэвх санаачилгатай ажиллах;

4.8.“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газраас хүлээлгэн өгсөн үнэ, үнэлгээ тодорхойгүй, цас цэвэрлэгээний болон нөхөөсний зориулалттай, 2 ширхэг тусгай зориулалт бүхий тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд үнэлж бүртгэх талаар Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх;

4.9.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх, үйл ажиллагаандаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах.

5.Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд, өссөн дүнгээр 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

6.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-эрдэнэ)-т нарт тус тус даалгасугай.

7.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын  
газрын 2023 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн  
4/2 дугаар тогтоолын хавсралт

“Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит компанид хийсэн  
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах  
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн /сая төгрөг/	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн	153.70	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд хувьцаа эзэмшигчийн хөрөнгийг захиран зарцуулах.
2	Төрийн өмчийн эд хөрөнгийн талаар Төрийн өмчийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаагүй.	38.10	
3	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгсэлд Улсын дугаар, гэрчилгээ гаргуулаагүй	8 ширхэг тээврийн хэрэгсэл	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг хэрэгжүүлэх, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллага, Авто тээврийн үндэсний төвтэй хамтран ажиллаж зөрчлийг арилгах, Өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх арга хэмжээ авах.
4	Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ суманд байрлах, шуурхайн байрны газар эзэмших эрхийг баталгаажуулаагүй, үнэлж бүртгэлд тусгаагүй.	1 ш газар	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлэн ажиллах.
<b>НИЙТ ДҮН:</b>		<b>191.8 /Нэг зуун ерэн нэгэн сая найман зуу/</b>	